

МОНГОЛ УЛС ДАХЬ ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ЦААШДЫН БОДЛОГО

*Ж.Уянга**

Япон улсын гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны нэг хэлбэр нь ODA буюу Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) юм. Японы Засгийн газрын хөгжлийн тусламж нь өнөөдөр дэлхийн шинэ тулгар хөгжиж байгаа олон орныг хамарч тэдгээр орнуудын хөгжлийн явц дахь тулгамдсан хүнд хэцүү асуудлуудыг шийдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Японы Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламжийг олгох гол нөхцөл нь улс орны хөгжлийн түвшинг илэрхийлдэг үндсэн үзүүлэлт болох нэг хүн амд ноогдох үндэсний орлого юмуу үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ байдаг. Монгол Улс Японы Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламжийг 1990 оноос эхлэн авч, шилжилтийн үеийн эдийн засгийн хямрал бэрхшээлийг даван туулахад зориулан ашиглаж иржээ.

Япон улс дэлхийн зуу гаруй оронд тусламж үзүүлж байгаагийн дотор Монгол Улс эхний аравт орж байгаа ба нэг хүнд оногдож буй тусламжийн хэмжээгээр нэгдүгээрт орж байна¹. Монгол Улсын хамгийн том хандивлагч орон нь Япон улс бөгөөд 1991 оноос өнөөг хүртэл Дэлхийн Банктай хамтарч Япон улс нийт арван удаа хандивлагчдын уулзалтыг зохион байгуулж, хандивлагчдаас амласан туслалцааны 60-аад хувийг дангаараа гаргаж байгаа болно. 1991 оноос 2000 оныг дуусах хүртэлх хугацаанд Япон улс нийтдээ 106 тэрбум 767 сая иены зээл тусламж олгоод байна. Ашиглаж эхлээд байгаа нийт зээл тусламжийн 19 хувийг зээл, 81 хувийг буцалтгүй тусламж эзэлж байгаа болно².

Япон улсын зээл тусламжийг үндсэн гол 4 салбарт авч ашиглаж байна:

1. Эдийн засгийн хөгжлийн үндсэн суурь болох дэд бүтцийн салбар
2. Хүний хөгжлийн хөтөлбөр
3. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар
4. Хүний амьдралын үндсэн хэрэгцээний тусламж. Үүнд:

Боловсрол, эрүүл мэнд, даатгалын зэрэг салбар юм.

Япон улсын Засгийн газраас олгож буй зээл тусламж нь манай орны бүхий л салбарыг хамарч Монгол Улсын хөгжилд ихээхэн хувь

*Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

нэмэр оруулж байгаа ба өнөөдөр Япон улсын тусламж хүртээгүй салбар, аймаг, сум, хувь хүн бараг үгүй байна. Япон улсаас Монгол Улсын төлбөрийн балансыг дэмжих зорилгоор нийт 9 удаа төслийн бус тусламж үзүүлээд байгаа бөгөөд ЖАЙКА-гийн шугамаар тодорхой салбаруудад хөгжлийн судалгаа хийж, техникийн хамтын ажиллагааны шугамаар хэд хэдэн төсөл хэрэгжүүлж, олон хүн сургаж байна.

Түүнчлэн манай улсад тохиолдсон цаг үеийн хүндрэл болох гал түймэр, ган зудыг даван туулахад ихээхэн хэмжээний буцалтгүй тусламж үзүүлж байсан болно.

Хоёр тал 1997 оны 3-р сард болсон эдийн засгийн дээд хэмжээний уулзалтын үеэр ХАЁТ-д хамруулах тэргүүлэх чиглэлийг тохирсон баримт бичиг үйлдсэн бөгөөд 2000 оны 10 сард болсон уулзалтын үеэр энэхүү баримт бичигт зарим нэгэн өөрчлөлт нэмэлт оруулсан билээ. Тухайлбал: жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, мэдээллийн технологийг хөгжүүлэх зэрэг болно.

Япон улсын тусламжтайгаар манай урд хил дээр бараа шилжүүлэн ачих байгууламж барьсан явдал нь манай улсын ачаа тээвэрлэлтийн хүчин чадлыг сайжруулаад зогсохгүй Монголоор дамжуулан бараагаа тээвэрлэдэг Хятад, Орос, Зүүн Европын орнуудад ч ихээхэн тустай болж олон улсын худалдааг хөгжүүлэхэд зохих дэмжлэг болсон гэж үзэж байна.

Мөн төвийн эрчим хүчний шугамаас алслагдсан 171 сумдын дизель станцыг шинэчилсэн, Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг шинэчлэн сайжруулсан нь хот, хөдөөгийн хөдөлмөрчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах, өвлийг тав тухтай давахад үнэлж баршгүй ач тус болсон билээ.

Сүүлийн жилүүдэд Япон улсын тусламжаар Улаанбаатар хотод нийтийн тээвэр, орон нутагт газар тариалангийн салбарт тус тус парк шинэчлэлт хийгдээд байгаа ба Монголд сансрын холбооны Интелсат системийн станцыг байгуулж өгсөн нь олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр болсон билээ.

Үүнээс гадна Японы тусламжаар 7 аймаг, 43 сум, Улаанбаатар хотын 4 дүүрэг, Улсын нэгдсэн II эмнэлэг, Хавдар судлалын төв, Эх нялхсын төв зэрэгт шаардлагатай зарим эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн бөгөөд энэ нь манай хот хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд маш их хувь нэмэр болсон билээ. Түүнчлэн Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын 16 сургуулийн хүчин чадлыг нь сайжруулж өргөтгөсөн явдал нь сурагчдын сурч боловсрох нөхцлийг

сайжруулж, сургууль завсардалтыг бууруулахад ихээхэн дэмжлэг болсон юм.

Японы Засгийн газрын тусламжийг дурьдвал үлэмж их бөгөөд манай улсын аливаа төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн хөгжил болон нийгмийн амьдралд бодитой хувь нэмэр оруулснаараа чухал ач холбогдолтой юм.

Цаашид Японы Засгийн газар Монголд олгож буй тусламжийн дээрх 4 гол салбар дээр:

- хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах
- хог хаягдлын асуудал гэсэн шинэ салбарт хөгжлийн тусламжийг олгох бодлого баримталж байна³. Хэрэв Монголын тал “Улаанбаатар хотын орчны бохирдлыг багасгах” төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг албан ёсоор Японы талд гаргавал Олон улсын хамтын ажиллагааны банк Жайка байгууллагатай хамтран судалгаа хийж, 2004 оны санхүүгийн жилд төсөл хэрэгжүүлэх юм байна.

Дэлхий нийтийг хамарсан шинжтэй эдийн засгийн таагүй байдлаас үүдэн Япон улс Засгийн газрын гадаадад үзүүлдэг нийт зээл тусламжийнхаа хэмжээг 1998 оноос хойш бууруулж байгаа бөгөөд харин Монгол Улсын хувьд тусламжийнхаа хэмжээг бууруулахгүй өмнөх түвшиндээ барих чиглэл баримталж ирсэн билээ.

Саяхан 2004 оны 9-р сард Япон улсын Гадаад хэргийн сайд хатагтай Ё.Кавагүчи манай оронд айлчилсан явдал нь хоёр орны иж бүрэн түншлэлийн харилцааг улам өргөжүүлэхэд жинтэй хувь нэмэр болж байгаа билээ. Айлчлалын явцад хатагтай Кавагүчи “Японы Засгийн газар Монгол Улсын ардчилал, шинэтгэлийг эхнээс нь дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч тусалцаагаа үргэлжлүүлнэ” гэж мэдэгдсэн байна⁴.

Мөн Японы Засгийн газар манай улсад олгох буцалтгүй тусламжийн тоо хэмжээг жилээс жилд өсгөж, харин хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэг түвшинд барих, эргэж төлөгдөх нөхцлийг судалж үзсэний үндсэн дээр зээлийг олгох зэрэг чиг бодлогыг барьж ирсэн бөгөөд энэ нь чухамдаа Монгол Улсыг ирээдүйд өрийн дарамтанд унагахгүй байх зорилго агуулсан сайн санааны илрэл, чухал алхам юм.

Үүнээс гадна Японы Засгийн газар Монгол Улстай ойрын 5 жилд хамтран ажиллах Хөгжлийн албан ёсны тусламжийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Манай орны хувьд эдийн засгийн тусламжийн хүрээнд улс орныг хөгжүүлэх энэ хөтөлбөрийг эдийн засгийн шинэчлэл, байгаль орчны асуудал, ядуурлыг бууруулах, бүс нутгийн

хөгжлийг дэмжих гэсэн чиглэлээр хэрэгжүүлэх юм байна. Тус хөтөлбөр манай орны Засгийн газартай эцэслэн тохирсны дагуу хүчин төгөлдөр болох юм.

Манай орны хувьд Японы ODA-гийн хэмжээг тогтвортой нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал байна. Үүний гол үндэс нь тусламжийн үр ашиг сайн байх явдал юм. Түүнчлэн, ард түмний амжиргааг дээшлүүлэхэд манай улс зээл тусламжийг хэрхэн үр ашигтай зарцуулсан ба ард түмний амьдралд бодитойгоор хэрхэн нөлөөлсөн эсэх нь цаашдын Японы ODA-гийн манай оронд баримтлах зээл тусламжийн бодлогод нөлөөлнө гэдгийг онцолж хэлмээр байна.

Сүүлийн үед улс орон өөрийн боломжид тулгуурлан, өөрийн хүчин чармайлтаар Засгийн газрын тусламжийг үр ашигтай ашиглах гэсэн ODA-гийн өөрчлөлтийн бодлогын⁵ дагуу манай улс орон Япон улсын зээл, тусламжийг Монголд хэрэгжүүлэх механизм, процедурыг ODA-гийн заавар журамтай уялдуулан өөрийн орны боломжид тулгуурлан нарийн боловсруулах шаардлагатай юм. Мөн эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд үндэслэн зээл тусламжийг ашиглах төлөвлөгөө боловсруулан түүнийгээ нарийн тооцоо судалгаагаар баталгаажуулж Японы талд сайн ойлгуулж харилцан уялдсан бодлого үйл ажиллагаа явуулах нь зүйтэй болов уу.

ODA-гийн санхүү Японы ард түмний татвараас бүтдэг учир сүүлийн үед Японы ард түмэн ODA-гийн зээл тусламж хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгааг мэдэхийг хүсэж байгаатай холбогдуулан ODA өөрчлөлт шинэчлэлтийн бодлогодоо зээл тусламжийн үр ашгийн талаар ард түмэндээ байнга мэдээлэх, ODA-гийн талаарх мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэхийн тулд “ард түмний оролцоо” гэсэн бодлого хэрэгжүүлж байгаа юм. Үүнтэй холбогдуулан манай оронд ч ODA-гийн талаарх мэдлэг, мэдээллийн баазыг Монголд өргөтгөх, зээл тусламжийн үр дүнгийн талаар мэдээлж байх, холбогдох дүрэм журам ном хэвлэл, бичиг баримтыг цуглуулж төвлөрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Б.Сэржав “Монгол-Японы харилцаа: XX зууны сүүлийн хагаст” УБ, 2003
2. Санхүү эдийн засгийн яамны мэдээлэл, УБ, 2003 он
3. JICA “Кокусай кёорёку жигёодан нэнпо”, 2003
4. “Зууны мэдээ” 2004.09.02, №208 /1718/
5. “Нихон ни нанига декирука? Сейфу кайхацу энжэ, ODA” Токио, 2003